



АКЗ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,  
Нийслэлийн засаг захирагааны 5 дугаар байр,  
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,  
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2016. 03. 04 № 244

таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,  
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА  
Ж.ГАНБОЛД ТАНАА

Санхүүгийн тайлангийн аудитын гэрчилгээ,  
аудитыг дуусгавар болгосон тухай тайланг хүргүүлж  
байна.

Хавсралт.... хуудас

ДЭД ДАРГА  Я.САМБУУНЯМ

D:\2016 on\yavuulsan bichig\2016.03.05 NBTSGazart .A5.docx

1110400274



НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,  
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА  
Ж.ГАНБОЛД ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
**НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,  
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,  
E-mail: ub@audit.gov.mn; <http://www.city.audit.mn>

2016.03.04 № 243

танай -ны № -т

**АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ**

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн аудитын газар аудит хийв.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Нийслэлийн аудитын газар нь Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын Олон Улсын Стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Нийслэлийн аудитын газар аудит хийхдээ Аудитын Олон Улсын Стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс анgid өсөх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хানгалттай бөгөөд зохистой үндэслэлийг бурдүүлсэн болно.

1110400273


## **Зөрчилгүй санал дүгнэлт**

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ц.ОЧИРБАТ



## НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг  
хүсвэл дараах хаягаар  
харилцана уу:

### Я.Самбууням

Нийслэлийн аудитын  
газрын дэд дарга  
өрөөний утас 327744

### Ц.Хосжаргал

Санхүүгийн аудитын  
менежер  
өрөөний утас: 315558

### Ц.Саранцэцэг

Ахлах аудитор  
өрөөний утас: 325093

**ТАБ-ЫН ХАЯГ:** Нийслэлийн  
аудитын газар

**Байршил:** Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг,  
Ж.Лхагвасүрэнгийн гудамж,  
Нийслэлийн засаг  
захиргааны V байр

**E mail:** [ub@audit.mn](mailto:ub@audit.mn)

**Вэб:** [www.city.audit.mn](http://www.city.audit.mn)

## Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Байгууллагаас ирүүлсэн хариу

Хавсралт 4: Аудитлагдсан санхүүгийн тайлан

Хавсралт 5: Аудитлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлан

## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланда хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохиорох загварын талаарх дүгнэлт

**Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1, 18.2-д заасан Нийслэлийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд / НАГ-2016/118/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Биеийн тамир, спортын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2015 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Нийслэлийн аудитын газрын үүрэг юм.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 1 дүгээр сарын 25-наас 2016 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн, Нийслэлийн аудитын газрын санхүүгийн аудитын II албаны III багийн ахлах аудитор Ц.Саранцэцэг 2015 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэв.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар 2015 оны санхүүгийн тайланг 2016 оны 1 дүгээр сарын 25-нд Нийслэлийн аудитын газарт ирүүлэв.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын удирдлэгэд аудитын гэрчилгээ, аудитын тайланг 2016 оны 3 дугаар сарын 4-нд хүргүүлж байна.

**Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын төсвийн захирагч нь Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Биеийн тамир, НАГ-2016/118/СТА-ТШЗ

спортын тухай хуулиуд болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулинд өөрчлөлт орсон ба энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Биеийн тамир, спортын тухай хуулийн 3.1.1. “Биөийн тамир” гэж нийгмийн соёлын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хүний бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх, хөдөлгөөний идэвхийг сайжруулах зорилгоор оюуны болон материаллаг үнэт зүйлийг бий болгох үйл ажиллагааг; 3.1.2. “спорт” гэж Биеийн тамирын хөгжлийн үр дүнд бий болсон тэмцээн, түүнд тусгай журмын дагуу бэлтгэж, оролцох үйл ажиллагааг; 3.1.11. “чийрэгжүүлэлт” гэж хүний хөдөлгөөний идэвхийг сайжруулах замаар эрүүл мэндийг бэхжүүлэх, нөхөн сэргээх үйл ажиллагааг. 3.1.10. “Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага” гэж Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн чиглэлээр ажил, үйлчилгээ үзүүлэх зорилго, чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг; хэлнэ” гэж энэ байгууллагын чиг үүргийг тодорхойлсон байна.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16.1 “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2015 оны төсвийн санхүүжилтийг Нийслэлийн төрийн сангаас олгосон байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хууль, журам, зааврын хэрэгжилт зарим талаараа хангалтгүй байна.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

**Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим , түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансадад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын, нарийвчилсан горим, сорил 5-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2014 онд нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн, түүнтэй нягтлан бodoх бүртгэлийн програм уялдсан байна.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайланг гаргасан байна.

#### Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт зарим талаараа хангалтгүй байна.

#### Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2015 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу нийслэлийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын төсвийн захирагч нь 2015 онд улсын төсвөөс урсгал зардалд 344,870.0 мянган төгрөгийн санхүүжилт, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлого 11,200.0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 335,106.0 мянган төгрөг буюу 9,764.0 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгогдож, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн бүрдүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтээр Эрүүл мэнд, спортын яамнаас 50,000.0 мянган төгрөг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 248,971.0 мянган төгрөг, Нийслэлийн төрийн сангаас хөрөнгө оруулалтын барьцааны мөнгө 14,255.8 мянган төгрөг,

үндсэн бус үйл ажиллагаанаас 5,248.6 мянган төгрөг, урьд оны төсвийн хэмнэлтээс 2,838.0 мянган төгрөг нийт 321,313.4 мянган төгрөгийн орлого орсон байна.

Ургал зардалд 344,854.0 мянган төгрөгийг зарцуулж, дутуу зарцуулсан санхүүжилтийн үлдэгдэл 1,452.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 5,248.6 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл 483.5, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1.1 мянган төгрөг нийт 7,185.2 мянган төгрөгийг Нийслэлийн төрийн санд буцаан төвлөрүүлжээ.

### Шилэн дансны мэдээлэл:

Нийслэлийн [www.shilendans.ub.dov.mn](http://www.shilendans.ub.dov.mn) цахим хуудсанд тус байгууллагын 2016 оны батлагдсан төсвийн хуваарь, 2016 оны 1-12 сарын төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээ, цалингийн зардлаас бусад зарлагын гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрүүдийн бүрэн байршуулсан байна.

### Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 5 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Дансны бичилт буруу хийсэн зөрчил нь санхүүгийн тайлангийн толилуулга ба илчлэл гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн тодруулгууд буруу илэрхийлэгдэхэд хүргэсэн байна.

### Гол, онцлог гүйлгээний талаарх(тохиromжтой бол) тайлбар

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 476,734.7 мянган төгрөгийн буюу нийт ажил гүйлгээ, үлдэгдлийн 68.0 %-ийг нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. Дансны бичилтийн зөв хийгдсэн эсэхийг 100.0% шалгасан. /ТАБ-СТА-В-3/

### Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараахь заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Спортын арга хэмжээнд зарцуулсан төсвийн хөрөнгийг урьдчилж гарсан зардлын дансаар дамжуулалгүй, зардалд шууд тусгасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.28 “Бэлтгэн нийлүүлэгч болон хувь хүмүүст төлсөн урьдчилгаа ба урьдчилан гарсан зардлыг Дт. Урьдчилж төлсөн төлбөрүүд Кт. Мөнгөн хөрөнгө/Дансны өглөг гэж бүртгэнэ” заалтыг зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Мөнгөн урьдчилгааны тайланг хариуцсан ажилтнуудаар гаргуулж хэвших зөвлөмж өгсөнийг хүлээн зөвшөөрсөн хариу ирүүлсэн.

2. Тус байгууллагын дарга ТЗ-10-5 сүлжээгээр цалинждаг бөгөөд дэд докторын нэмэгдлийг сар бүр 10 хувиар тооцон, 2015 онд 1,032.0 мянган төгрөг авсан байна. Нийслэлийн Засаг дарга албан тушаалд томилох тушаал гаргахдаа дэд докторын нэмэгдлийг олгохоор зааж, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл олгох тухай” журмын 4. “Энэ журмын 2-т зааснаас бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа докторын зэрэгтэй төрийн албан хаагчид албан тушаалын сарын цалингийн 15 хувиар, дэд докторын зэрэгтэй төрийн албан хаагчид албан тушаалын сарын цалингийн 10 хувиар тооцож нэмэгдэл олгоно. Харин профессор, дэд профессор цолны нэмэгдлийг **зөвхөн энэ журмын 2-т дурдсан** ажил, үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид олгоно.”, 2. “Их, дээд сургууль, коллеж, ТМДС, MCYT-д сургалт, эрдэм шинжилгээ, туршилтын ажил эрхэлдэг, эрдэм шинжилгээний байгууллагад болон судалгаа шинжилгээ, туршилтын үндсэн үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа эрдмийн зэрэг, цолтой төрийн албан хаагчид ...”, Төрийн албаны тухай хуулийн 28.3. “Төрийн жинхэнэ албан хаагчид цол, зэрэг дэвийн нэмэгдлийг **дэвхардуулан олгохгүй**.”, Төсвийн тухай хуулийн 4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалтуудыг зөрчсөн шийдвэр гаргасан байна.

- Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, эрхийн актуудыг мөрдөн ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөнийг хүлээн зөвшөөрсөн хариу ирүүлсэн.

3. Байгууллагад олгосон 6,650.0 мянган төгрөгийн шагналаас хувь хүний орлогын албан татвар 10 хувиар 665.0 мянган төгрөг суутган авч, татварт шилжүүлсэн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 5.1. “Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл тийм орлого олоогүй ч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий Монгол Улсад оршин суугч Монгол Улсын **иргэн**, гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн дагуу албан татвар төлөгч байна.” заалтыг зөрчиж байна.

- Шийдвэрлэсэн нь: Байгууллагад олгосон шагналаас ХХОАТ суутгадаг зөрчлийг зогсоох зөвлөмж өгсөнийг нь хүлээн зөвшөөрсөн хариу ирүүлсэн.

### Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Хууль, журам зөрчсөн 1,697.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулаагүй болно.

### Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

**Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд**

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд байхгүй.

**Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,697.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Төсвийн захирагчийн төсвийн 2013 оны санхүүгийн тайланд НАГ-ын хийсэн аудитаар З зөвлөмж өгсөнөөс “Мөнгөн урьдчилгааны тайлан”-г хариуцсан ажилтнуудаар гаргуулж хэвших зөвлөмж хэрэгжээгүй, 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.


**Зөрчилгүй санал дүгнэлт**


Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас, менежментийн захидал 4 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**ХЯНАСАН:**

ДЭД ДАРГА  Я.САМБУУНЯМ

АУДИТЫН МЕНЕЖЕР  Ц.ХОСЖАРГАЛ

**БЭЛТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР

 Ц.САРАНЦЭЦЭГ

2016.03.04



## НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг  
хүсвэл дараах хаягаар  
харилцана уу:

### Я.Самбууным

Нийслэлийн аудитын  
газрын дэд дарга  
өрөөний утас: 327744

### Ц.Хосжаргал

Санхүүгийн аудитын  
менежер  
өрөөний утас: 315558

### Ц.Саранцэцэг

Ахлах аудитор  
өрөөний утас: 325093

## Менежментийн захидал

### Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1	3
Зардал.....	
Асуудал 2	
Цалингийн зардал	
.....	3-4
Асуудал 3	
Өглөг.....	4

**ТАБ-ЫН ХАЯГ:** Нийслэлийн  
аудитын газар

**Байршил:** Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг,  
Ж.Лхагвасүрэнгийнгудамж,  
Нийслэлийн засаг  
захиргааны V байр

**E mail:** [ub@audit.mn](mailto:ub@audit.mn)

**Вэб хаяг:** [www.city.audit.mn](http://www.city.audit.mn)

2016 оны 2 дугаар сар 29

## Менежментийн захидал

Нийслэлийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидалыг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидалын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Нийслэлийн Аудитын газрын энэхүү зөвлөмж нь та бүхний бүртгэл, тайлagnal, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

## Асуудал 1: Зардал

### НАГ-ЫН АЖИГЛАЛТ

Спортын арга хэмжээнд зарцуулсан мөнгийг урьдчилж гарсан зардлын дансаар дамжуулалгүй, зардалд шууд тусгасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.28 “Бэлтгэн нийлүүлэгч болон хувь хүмүүст төлсөн урьдчилгаа ба урьдчилан гарсан зардлыг Дт. Урьдчилж төлсөн төлбөрүүд Кт. Мөнгөн хөрөнгө/Дансны өглөг гэж бүртгэнэ” заалтыг зөрчсөн байна.

### ЭРСДЭЛҮҮД

Санхүүгийн тайланд авлага, өглөг дутуу тусгагдах,  
Мөнгөн хөрөнгө шамшигдах.

## ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №1

### НАГ-ЫН ЗӨВЛӨМЖ

Мөнгөн урьдчилгааны тайланг хариуцсан ажилтануудаар гаргуулж байх.

## ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН ХАРИУ

## Асуудал 2: Цалингийн зардал

### НАГ-ЫН АЖИГЛАЛТ

Тус байгууллагын дарга ТЗ-10-5 сүлжээгээр цалинждаг бөгөөд дэд докторын нэмэгдлийг сар бүр 15 хувиар тооцон, 2015 онд 1,032.0 мянган төгрөг авсан байна. Нийслэлийн Засаг дарга албан тушаалд томилох тушаал гаргахдаа дэд докторын нэмэгдлийг олгохоор зааж, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл олгох тухай” журмын 4. “Энэ журмын 2-т зааснаас бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа докторын зэрэгтэй төрийн албан хаагчид албан тушаалын сарын цалингийн 15 хувиар, дэд докторын зэрэгтэй төрийн албан хаагчид албан тушаалын сарын цалингийн 10 хувиар тооцож нэмэгдэл олгоно. Харин профессор, дэд профессор цолны нэмэгдлийг **ЗӨВХӨН ЭНЭ ЖУРМЫН 2-Т ДУРДСАН** ажил, үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид олгоно.”, 2. “Их, дээд сургууль, коллеж, ТМДС, MCYT-д сургалт, эрдэм шинжилгээ, туршилтын ажил эрхэлдэг, эрдэм шинжилгээний байгууллагад болон судалгаа шинжилгээ, туршилтын үндсэн үйлдвэрлэл

## ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №2

### НАГ-ЫН ЗӨВЛӨМЖ

Холбогдох хууль, эрхийн актуудыг мөрдөн ажиллах,  
Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

дээр ажиллаж байгаа эрдмийн зэрэг, цолтой төрийн албан хаагчид ...”, Төрийн албаны тухай хуулийн 28.3. “Төрийн жинхэнэ албан хаагчид цол, зэрэг дэвийн нэмэгдлийг **давхардуулан олгохгүй.**”, Төсвийн тухай хуулийн 4.1.”төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалтуудыг зөрчсөн шийдвэр гаргасан байна.

### Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулах.

#### **Асуудал 3: Хувь хүний орлогын албан татварын өглөг**

##### НАГ-ЫН АЖИГЛАЛТ

Байгууллагад олгосон 6,650.0 мянган төгрөгийн шагналаас хувь хүний орлогын албан татвар 10 хувиар 665.0 мянган төгрөг суутган авч, татварт шилжүүлсэн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 5.1.”Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл тийм орлого олоогүй ч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий Монгол Улсад оршин суугч Монгол Улсын **иргэн**, гадаадын иргэн, харьялалгүй хүн энэ хуулийн дагуу албан татвар төлөгч байна.” заалтыг зөрчиж байна.

##### Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомжийг хэргжүүлэхгүй байх

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.  
ХХОАТтатварын тайлан буруу илэрхийлэгдэх

#### **ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №3**

##### НАГ-ЫН ЗӨВЛӨМЖ

Байгууллагад олгосон шагналаас ХХОАТ суутгадаг зөрчлийг зогсох.

##### Төсвийн захирагчийн хариу

#### **МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ**

ХЯНАСАН:  
ДЭД ДАРГА

J. Sambuu

Я.САМБУУНЯМ

2016.02.29

АУДИТЫН МЕНЕЖЕР

C. Hoscargal

Ц.ХОСЖАРГАЛ

2016.02.26

БЭЛТГЭСЭН:  
АХЛАХ АУДИТОР

C. Saranczeg

Ц.САРАНЦЭЦЭГ

2016.02.23

НАГ-2016/118/СТА-ТШЗ

**Байгууллагаас ирүүлсэн хариу**

И. Сандувучирхэлт  
Н. Оюунжаргал  
11/3




НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР  
4200 Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо.  
А. Амарын гудамж. Соёлын төв өргөө  
Утас: 31-27-85. Факс: (976-11) 32-89-77  
<http://www.sport.ub.gov.mn>  
E-mail: it@sport.ub.gov.mn

2016.05.05 № 01/45  
танийн 2016.09.29 № 229 -т

Г НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Менежментийн захидалтай танилцлаа.  
НБТСГ-ЫН дарга нь Нийслэлийн Засаг даргын 2012  
оны 03 дугаар сарын 29-ны өдрийн Б/12 дугаар  
захирамжинд заагдсанаар дэд докторын  
нэмэгдлийг 10 хувиар авдаг юм. Иймд  
менежментийн захидалд дурьдсан 15 хувь гэснийг  
залруулах шаардлагатай байна. Бусад асуудлыг  
цаашид байгууллагын үйл ажиллагаанд мөрдлөг  
болгон ажиллана.



1150500093

НАГ-2016/118/СТА-ТШ3

## Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,407,927.32</b>	<b>4,107,125.00</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	1,102.32	-
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	1,102.32	-
31110	Төгрөг	1,102.32	-
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>3,406,825.00</b>	<b>4,107,125.00</b>
35400	Хангамжийн материал	3,406,825.00	4,107,125.00
35410	Бичиг хэргийн материал	746,900.00	1,113,650.00
35420	Аж ахуйн материал	2,659,925.00	2,393,475.00
35440	Түлш, шатах тослох материал	-	600,000.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>39,215,816.49</b>	<b>25,367,551.24</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>39,215,816.49</b>	<b>25,367,551.24</b>
39200	Биет хөрөнгө	39,215,816.49	25,367,551.24
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	22,376,202.00	22,376,202.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,359,769.34)	(19,906,010.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,253,379.90	38,253,379.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,053,996.07)	(15,356,019.91)
39301	Програм хангамж	280,000.00	280,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(280,000.00)	(280,000.00)
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>42,623,743.81</b>	<b>29,474,676.24</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>42,623,743.81</b>	<b>29,474,676.24</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>42,623,743.81</b>	<b>29,474,676.24</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	58,011,395.49	58,011,395.49
51101	Өмч: төрийн	58,011,395.49	58,011,395.49
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(15,387,651.68)</b>	<b>(28,536,719.25)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(11,882,867.48)	(15,387,651.68)
51220	Тайлант үеийн үр дүн	(3,504,784.20)	(13,149,067.57)
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>* 42,623,743.81</b>	<b>29,474,676.24</b>

## Аудит хийгдсэн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2015 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>654,715,933.00</b>	<b>667,619,417.37</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>34,531,123.00</b>	<b>19,286,617.37</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>34,531,123.00</b>	<b>19,286,617.37</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,531,123.00	19,286,617.37
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	11,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,333,000.00	5,248,581.61
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	25,224,600.00	2,838,035.76
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,973,523.00	-
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>620,184,810.00</b>	<b>648,332,800.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>620,184,810.00</b>	<b>385,106,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	342,521,810.00	335,106,000.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	227,663,000.00	50,000,000.00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдхөх	50,000,000.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>-</b>	<b>263,226,800.00</b>
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	263,226,800.00
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>658,220,717.20</b>	<b>680,768,484.94</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>658,220,717.20</b>	<b>680,768,484.94</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>639,360,769.17</b>	<b>673,013,246.57</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>94,310,048.00</b>	<b>109,148,828.00</b>
210101	Үндсэн цалин	94,310,048.00	106,348,828.00
210104	Урамшуулал	-	2,800,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>10,261,089.00</b>	<b>11,468,192.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	6,439,089.00	7,226,292.00
210202	Тэтгэмжийн даатгал	778,000.00	848,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	956,000.00	1,060,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	178,000.00	212,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,910,000.00	2,121,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,904,868.00</b>	<b>12,778,397.00</b>
210401	Бичиг хэрэг	1,364,315.00	2,844,500.00
210402	Тээвэр, шатахуун	6,285,274.00	6,815,673.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,060,579.00	3,118,224.00
210404	Ном, хэвлэл	54,000.00	-
210405	Хог хаягдал зайлзуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	140,700.00	-
2107	<b>Томилот, зочны зардал</b>	<b>739,000.00</b>	<b>210,000.00</b>
210702	Дотоод албан томилот	739,000.00	210,000.00

НАГ-2016/118/СТА-ТШ3

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2015 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний толбөр, хураамж</b>	251,724,149.00	217,124,582.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	249,459,349.00	196,401,622.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	60,500.00	34,600.00
210807	Газрын төлбөр	-	370,060.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	602,500.00
210813	Бусад зардал	2,204,300.00	19,385,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	272,421,615.17	322,283,247.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	267,060,918.00	308,434,982.32
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,360,697.17	13,848,265.25
<b>213</b>	<b>ҮРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	18,859,948.03	7,755,238.37
<b>2132</b>	<b>Бусад ургал шилжүүлэг</b>	400,000.00	570,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	400,000.00	570,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	18,459,948.03	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,459,948.03	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	7,185,238.37
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,185,238.37
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(3,504,784.20)</b>	<b>(13,149,067.57)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(3,504,784.20)</b>	<b>(13,149,067.57)</b>

### Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

*/төгрөгөөр/*

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>654,715,933.00</b>	<b>667,619,417.37</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>34,531,123.00</b>	<b>19,286,617.37</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>* 34,531,123.00</b>	<b>19,286,617.37</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,531,123.00	19,286,617.37
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,973,523.00	11,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,333,000.00	5,248,581.61
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	25,224,600.00	2,838,035.76
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>620,184,810.00</b>	<b>648,332,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>342,521,810.00</b>	<b>385,106,000.00</b>

НАГ-2016/118/СТА-ТШ3

**НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2015 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	342,521,810.00	335,106,000.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	50,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>277,663,000.00</b>	<b>263,226,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	227,663,000.00	-
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	50,000,000.00	263,226,800.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>654,717,520.03</b>	<b>667,620,519.69</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>654,717,520.03</b>	<b>667,620,519.69</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>633,653,272.00</b>	<b>659,865,281.32</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>94,982,523.00</b>	<b>108,748,827.00</b>
210101	Үндсэн цалин	94,982,523.00	105,948,827.00
210104	Урамшуулал	-	2,800,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>10,261,089.00</b>	<b>11,468,193.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	6,439,089.00	7,226,293.00
210202	Тэтгэмжийн даатгал	778,000.00	848,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	956,000.00	1,060,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	178,000.00	212,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,910,000.00	2,121,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>-</b>	<b>5,130,000.00</b>
210304	Байрны түрээс	-	5,130,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,709,053.00</b>	<b>11,592,240.00</b>
210401	Бичиг хэрэг	1,238,500.00	2,668,500.00
210402	Тээвэр, шатахуун	7,215,274.00	5,755,516.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,060,579.00	3,118,224.00
210404	Ном, хэвлэл	54,000.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлзуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	140,700.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>739,000.00</b>	<b>210,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	739,000.00	210,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>206,967,432.00</b>	<b>209,934,729.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	205,906,932.00	208,423,769.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	332,300.00	208,400.00
210807	Газрын төлбөр	-	370,060.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	728,200.00	602,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>309,994,175.00</b>	<b>312,781,292.32</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	309,994,175.00	312,781,292.32

НАГ-2016/118/СТА-ТШ3

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2015 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,064,248.03	7,755,238.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,604,300.00	570,000.00
213204	Ажил олгогчоос олгохбусад тэтгэмж, урамшуулал	2,604,300.00	570,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,459,948.03	7,185,238.37
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,459,948.03	7,185,238.37
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(1,587.03)	(1,102.32)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(1,587.03)	(1,102.32)
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,689.35	1,102.32
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,102.32	0.00

**Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дун
1	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	58,011,395.49	(11,882,867.48)	46,128,528.01
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	58,011,395.49	(11,882,867.48)	46,128,528.01
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	(3,504,784.20)	(3,504,784.20)
8	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	58,011,395.49	(15,387,651.68)	42,623,743.81
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2015 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	(13,149,067.57)	(13,149,067.57)
16	2015 оны 12-р сарын 31-нээрх улдэгдэл	58,011,395.49	(28,536,719.25)	29,474,676.24

**Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

ЭЗ Ангилал 2015	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	356,070,000.00	344,853,989.00	-11,216,011.00	96.85
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	356,070,000.00	344,853,989.00	-11,216,011.00	96.85
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	356,070,000.00	344,853,989.00	-11,216,011.00	96.85
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	106,049,600.00	105,948,827.00	-100,773.00	99.90
210101	Үндсэн цалин	106,049,600.00	105,948,827.00	-100,773.00	99.90
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	11,665,400.00	11,468,193.00	-197,207.00	98.31
210201	Тэтгэврийн даатгал	7,423,500.00	7,226,293.00	-197,207.00	97.34
210202	Тэтгэмжийн даатгал	848,400.00	848,400.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,060,500.00	1,060,500.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	212,000.00	212,000.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,121,000.00	2,121,000.00	-	100.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,364,300.00	5,130,000.00	-234,300.00	95.63
210304	Байрны түрээс	5,364,300.00	5,130,000.00	-234,300.00	95.63
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,669,200.00	11,592,240.00	-1,076,960.00	91.50
210401	Бичиг хэрэг	2,990,800.00	2,668,500.00	-322,300.00	89.22
210402	Тээвэр, шатахуун	5,755,800.00	5,755,516.00	-284	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,777,800.00	3,118,224.00	-659,576.00	82.54
210404	Ном, хэвлэл	144,800.00	50,000.00	-94,800.00	34.53
2106	<b>Эд хогшил, ургал засварын зардал</b>	1,444,900.00	*	-1,444,900.00	
210604	Ургал засвар	1,444,900.00	-	-1,444,900.00	
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	837,200.00	210,000.00	-627,200.00	25.08
210702	Дотоод албан томилолт	837,200.00	210,000.00	-627,200.00	25.08
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	217,438,100.00	209,934,729.00	-7,503,371.00	96.55

НАГ-2016/118/СТА-ТШ3

**НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2015 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	214,845,600.00	208,423,769.00	-6,421,831.00	97.01
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,592,500.00	1,510,960.00	-1,081,540.00	58.28
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	601,300.00	570,000.00	-31,300.00	94.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	601,300.00	570,000.00	-31,300.00	94.79
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>356,070,000.00</b>	<b>344,853,989.00</b>	<b>-11,216,011.00</b>	<b>96.85</b>
<b>31</b>	<b>ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	344,870,000.00	333,203,989.00	-11,666,011.00	99.73
310001	төсвөөс санхүүжих	344,870,000.00	333,203,989.00	12,116,011.00	96.49
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	11,200,000.00	11,650,000.00	-	100.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,200,000.00	11,200,000.00	-	100.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	450,000.00	-	-
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	8	8	-	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	8	8	-	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	-	100.00

**Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>315,581,292.32</b>
<b>21</b>	<b>ҮРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>315,581,292.32</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>315,581,292.32</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	<b>2,800,000.00</b>
210104	Урамшуулал		2,800,000.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>315,581,292.32</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>315,581,292.32</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		50,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		262,743,256.56
131106	Төсвийн урамшуулал		2,838,035.76

НАГ-2016/118/СТА-ТШ3